МЭДЭЭ · 2026 оны 1-р сарын 8

ХАР ТАМХИ, МАНСУУРАЛТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх алба хамтран 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр хар тамхи, мансууралтай тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Энэхүү хэлэлцүүлгийн зорилго нь мансуурууулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал, аргачлал, зөвлөмж боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад уламжлах, мөрдөх байгууллагатай хамтран хэрэгжүүлэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ажил, арга хэмжээг тодорхойлох, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдах албан тушаалтнууд хэлэлцүүлэгт оролцож, санал солилцов.




Улсын ерөнхий прокурорын газраас энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг 2022-2024 он, 2025 оны 10 дугаар сарын байдлаар судалсан дүн, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан шийдвэрийг хүчингүй болгож, нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн хэргийн талаар танилцуулж, хуулийг нэг мөр хэрэглэх чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүллээ.




Хэлэлцүүлгийн төгсгөлд, хар тамхи, мансууралтай тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх бодлого чиглэлийг тодорхойлж, хуулийг нэг мөр хэрэглэх, хэрэгжилтийг хангуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудлын хүрээнд хамтарсан зөвлөмж гаргах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад уламжлахаар шийдвэрлэв.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/594